ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2020 оны 02 сарын 27 өдөр Дугаар 03/42 Чойр

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд "Аймгийн Засаг даргын тамгын газар"-ын 2019 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- 2018 оны үр дүнгийн гэрээний үнэлгээгээр мөнгөн урамшуулал олгосон, мөн ажилтны цалингийн шатлалыг өмнөх онд нэмэгдүүлсэн атлаа журам зөрчиж дахин шатлал нэмэгдүүлж 764.5 мянга, сахилгын шийтгэлтэй ажилтанд 293.1 мянган төгрөгийг урамшуулалд тус тус илүү тооцож олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 2 дугаар зүйлийн 2.7, Засгийн газрын 2014 оны 147 дугаар тогтоол, УИХ-ын 2016 оны 47 дугаар тогтоолуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт, албан шаардлага өгөх ...", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн аудитын шийдвэрлэлтийн аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3.1 дэх хэсгийг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Илүү тооцож олгосон цалин, урамшууллын нийт 1,057,689.00 төгрөгийг жагсаалтын дагуу холбогдох этгээдээр төлүүлж, аймгийн Төрийн сан дахь Орон нутгийн орлогын /Төсөвт байгууллагын өөрийн орлого/ 100220000954 тоот дансанд төвлөрүүлэх
2. Актын биелэлтийг 2020 оны 05 дугаар сарын 20-ны дотор гаргаж, Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн Засаг даргын тамгын дарга Д.Содном, нягтлан бодогч Б.Гүнжидмаа нарт хариуцуулав.

АКТЫГ

ТОГТООСОН[1]:
АХЛАХ АУДИТОР Ц.БАТСАЙХАН

ХЯНАСАН:
АУДИТЫН МЕНЕЖЕР Г.НАРАНБАЯР

ЗӨВШӨӨРСӨН:
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА Д.СОДНОМ

НЯГТЛАН БОДОГЧ: Б.ГҮНЖИДМАА

[1] *Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.*

9911666183